

# ХОВД АЙМАГ ДАХЬ САЛБАР ТАНХИМЫН ДҮРЭМ

## Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

1.1.Ховд аймаг дахь Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын салбар нэгж/МҮХАҮТ-ын Ховд аймаг дахь салбар гэх/ бөгөөд үндэсний танхимын үндсэн чиг үүргийг тухайн орон нутагт бүхэлд нь буюу хэсэгчилэн гүйцэтгэнэ.

1.2.МҮХАҮТ-ын Ховд аймаг дахь салбар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

1.3.МҮХАҮТ-нь Үндэсний Танхимын зорилт, бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах ба өөрийн нэр бүхий тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

## Хоёрдугаар зүйл. МҮХАҮТ-ын Ховд аймаг дахь салбар танхимын зорилго, эрх, үүрэг

### 2.1. Зорилго

2.1.1 Бизнесийн болон орон нутгийн хөгжилд, гишүүнчлэл, нөлөөллийн үйл ажиллагаагаар Ховд аймгийн бизнес эрхлэгчдийг чадавхижуулах, хөгжүүлэх, эрхийг нь хамгаалан ажиллана.

### 2.2. Салбар танхим нь дараах үүрэгтэй

2.2.1. Салбар танхимын гишүүд болон худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийн нийтлэг эрх ашиг, сонирхлыг илэрхийлэн хамгаалах

2.2.2. Монгол улсын гадаад худалдаа, экспортыг дэмжих, худалдаа үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих

2.2.3. Бизнесийн үйл ажиллагааны талаархи тухайн нутаг дэвсгэрийн орчинг судалж, анализ хийж, энэхүү чиглэлээр гарч байгаа хууль, тогтоомж, актад зохих нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг Үндэсний танхимд илэрхийлэх

2.2.4. Монголын бараа, үйлчилгээний экспортыг дэмжин, дотоодын байгууллага, бизнес эрхлэгчдийг гадаад орны түншүүдтэй ажил хэрэгч, шинэ хэлбэрийн эдийн засаг, хамтын ажиллагааны харилцаа холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх

2.2.5. Мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн ололтыг нэвтрүүлэх, электрон харилцааг танхимын гишүүн байгууллагууд болон Монгол улсад хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх идэвхитэй хамтран ажиллах

2.2.6. Аж ахуйн нэгж, банк, санхүүгийн байгууллага, аймаг, орон нутгийн хүсэлтээр тэдгээрийн хөрөнгө оруулалтын боломж, бизнесийн ерөнхий чадамжийг судлан зээлийн зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлж, зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх

2.2.7. Гадаад, дотоодын эдийн засаг, эрдэм шинжилгээний байгууллагууд, үйлдвэр, худалдааныхантай судалгааны олон ажил хэргийн групп солилцох, уулзалт ярилцлага, бага хурал, эрдэм шинжилгээ, онол практикийн хурал зохион байгуулж оролцох

2.2.8. Салбар танхимын гишүүн байгууллага болон сонирхсон байгууллагууд, үйлдвэр, худалдаа эрхлэх, гадаад харилцааг өргөжүүлэх, түншлэх бусад хамтын ажиллагааг өргөжүүлэхэд доорхи үйлчилгээ дэмжлэгийг үзүүлнэ.

Үүнд.

а/ Гадаад, дотоодын зах зээлийн мэдээлэл солилцох, үйлдвэр худалдааны түнш эрж олохтой холбогдсон мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах

б/ Орон нутагтаа үйлдвэр худалдааны олон улсын болон улсын хэмжээний төрөлжсөн үзэсгэлэн яармаг зохион байгуулах, энэ талаар үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай нягт уялдаа холбоотой ажиллах

в/ Бизнес эрхлэгчид, гишүүдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан сургалт, зөвөлгөө, уулзалтуудыг зохион байгуулах

г/ Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас олгодог гарал үүслийн гэрчилгээ, зураасан код, патент, газарзүйн заалт зэрэг үйлчилгээ болон бусад үйлчилгээний талаар бизнес эрхлэгчидэд тодорхой мэдээлэл өгч, дэмжлэг үзүүлэх

д/ Гадаад, дотоодын салбар танхимын гишүүн байгууллага, хувь хүмүүсийнхээ ашиг сонирхолыг төлөөлж, тэдгээрт оруулах хөрөнгө оруулалт, жижиг дунд бизнесийг хөхүүлэн дэмжих

2.2.9. Тухайн салбарт орон нутаг дахь салбар арбитрыг ажиллуулж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх

2.2.10. Монголын экспортын барааны гарал үүслийн гэрчилгээ олгож мөн гарал үүсэл тодорхойлох болон баталгаажуулах талаар холбогдох журам боловсруулан баталж, мөрдөн ажиллах

2.2.11. Гишүүн байгууллагынхаа хүний нөөцийн хөгжлийг дэмжих, чадварлаг боловсон хүчнээр хангах зорилгоор, бизнес эдийн засгийн боловсролын чиглэлээр магадлан итгэмжлэх үйл ажиллагаа явуулах

2.2.12. Гишүүн байгууллагынхаа захиалгаар удирдлага, эдийн засаг, бизнес хууль эрхзүйн асуудлаар зөвөлгөө өгөх урт богино хугацааны сургалт зохион байгуулах, орчуулга хийх

2.2.13. Гадаад дотоодын аж ахуйн нэгж, нийгэмлэг, байгууллагуудад үйлдвэр, үйлчилгээ, худалдаа эрхлэх болон зах зээл санхүү, валютын арилжааны талаар мэдээлэл, зөвлөмж өгч, төрөл бүрийн хэлбэрээр холбогдох ном, сэтгүүл лавалгааны материал гаргах, гадаадын компаниудад тэдний хүсэлтээр монголын компаниудын найдвартай түншийн лавлагаа өгөх, бүртгэл хөтлөх

2.2.14. Экспертүүдийн улсын албан бус бүртгэл хөтлөх

2.2.15. Хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийг дэмжих зорилгоор төслийн үнэлгээ, зээлийн зэрэглэл тогтоох чиглэлд гадаад, дотоодын банк, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах

2.2.16 Бизнесийн үйл ажиллагаандаа амжилт гаргаж буй аж ахуйн нэгж байгууллага, идэвхи зүтгэл гаргасан хувь хүнийг Үндэсний танхимын одон, бусад шагналаар шагнаан урамшуулах, Монгол улсын төрийн одон медаль, бусад шагналд тодорхойлох

2.2.17. Байгаль орчинд халгүй цэвэр үйлдвэрлэл, үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг хөгжүүлэх, энэ чиглэлийн хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, гадаад дотоодын болон олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх

2.2.18. Олон улсын худалдааны танхим болон олон улсын худалдаанд хэвшин тогтсон, энэхүү дүрэмд дурьдагдаагүй бусад түгээмэл үйл ажиллагааг хэрэгжүүлэх

2.2.19. Салбар танхимын үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагааг явуулах

2.3. Салбар танхим нь дараах эрхтэй

2.3.1. Салбар танхимын гишүүн болон худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн хууль ёсны эрх ашгийг өөрийн харъяа орон нутгийн өөрөө удирдах ёсны болон төрийн захиргааны байгууллагуудад төлөөлөн хамгаалах, төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг тодорхойлоход санал, дүгнэлтээ гаргаж Үндэсний танхимд илэрхийлэх

2.3.2. Хөрөнгө оруулалт, худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ, танхимын дотоод үйл ажиллагааг дэмжих зорилгоор салбар танхимын дэргэд төрөл бүрийн сан ажиллуулах, төсөл хэрэгжүүлэх

2.3.3. Өөрийн эрх хэмжээний хүрээнд гадаад, дотоодын бизнесийн байгууллагууд болон хувь хүмүүстэй бизнесийн хэлцэл хийх, харилцаа холбоо тогтоох, гэрээ, хэлэлцэл, проткол, санамж бичиг байгуулж хэрэгжүүлэх

2.2.4. Төр засгийн болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах санал, дүгнэлтээ гарган холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлж ажиллах зорилгоор салбарын зөвлөлүүд байгуулж ажиллуулах

2.2.5. Монгол улсад болон гадаадад үл хөдлөх эд хөрөнгө эзэмших, захиран зарцуулах, түрээслэх, түрээслүүлэх

2.2.6. Газрын өмчлөл, ашиглалтын харилцаанд оролцох, газрын тухай асуудлаар тухайн нутаг дэвсгэрийн бизнесийн хүрээнийхний санал бодлыг үндэсний танхимд илэрхийлэх

2.2.7. Салбар танхимын зорилго, үйл ажиллагааны хүрээний асуудлаар сонин, сэтгүүл, эмхэтгэл гаргах

2.2.8. Салбар танхимын гишүүдийнхээ худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхтэй холбогдсон эрх ашгийг нэтгэн уялдуулахын зэрэгцээ, шударга бус өрсөлдөөн, бусад бизнесийн халдлагаас хамгаалах арга хэмжээ авах.

### Гуравдугаар бүлэг. Гишүүнчлэл

3.1. Салбар танхимын гишүүн, түүний эрх үүрэг.

3.1. Салбар танхимын гишүүн нь энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр нэгдсэн буюу элссэн, холбогдох хуулийн дагуу байгуулагдсан дотоод, гадаадын аж ахуй нэгж, байгууллага, иргэн байна.

3.2. Салбар танхимын гишүүн бол Аж ахуй нэгж байгууллага жилдээ 150 000 төгрөг, хувь хүн 50 000 төгрөг төлнө.

3.3. Гишүүд нь өөрийн эрх ашгийг хамгаалж ажиллах салбар танхимын үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлэн ажиллана.

3.4. Гишүүн нь гишүүнчлэлээс татгалзсан тухай өргөдлөө танхимд гаргаснаар гишүүнээс чөлөөлөгдөнө. Энэ тохиолдолд гишүүний татварыг буцаан олгохгүй..

3.5. Гишүүн хоёр жил дараалан гишүүний татвараа төлөөгүй буюу энэхүү дүрмийн.

3.7-д заасан үүргээ биелүүлээгүй бол танхимын чөлөөлөхөөс 30 хоногийн өмнө бичгээр сануулж чөлөөлнө.

3.6. Гишүүн дараах эрхтэй байна.

3.6.1. Танхимын удирдах байгууллагыг сонгох, сонгогдох

3.6.2. Бүх гишүүдийн хурлаас сонгогдсон салбар танхимын гишүүн Үндэсний танхимын их хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудалд санал өгөх

3.6.3. Салбар танхимын гишүүн нь салбар танхимын бүх гишүүдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудалд санал өгөх

3.6.4. Үндэсний танхимын болон салбар танхимын удирдах байгууллагад санал, дүгнэлт, хүсэлт гаргах

3.6.5. Өөрсдийн эрх ашиг, сонирхолын хүрээ, хөрөнгийн хэмжээ, орон нутгийн харъяалал болон бусад ялгаагаар зөвлөл, хороо, дэд хороо болон зохион байгуулагдаж Танхимын үйл ажиллагаанд оролцох

3.6.6. Тэргүүн ээлжинд хөнгөлөлттэй нөхцлөөр Үндэсний болон салбар танхимаар үйлчлүүлэх

3.7. Гишүүн дараах үүрэгтэй.

3.7.1. Үндэсний болон салбар танхимын үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцох

3.7.2. Гишүүний татварыг тогтоосон журмын дагуу хугацаанд нь төлөх

3.7.3. Шударга өрсөлдөөнийг эрхэмлэх

3.7.4. Бизнесийн ёс зүйг чандлан сахих

### Дөрөвдүгээр бүлэг. Удирдлага, зохион байгуулалт

4.1. Салбар танхимын удирдах байгууллага нь:

- 4.1.1. Салбар танхимын бүх гишүүд
- 4.1.2. Салбар танхимын тэргүүлэгчид
- 4.1.3. Салбар танхимын Ерөнхийлөгч
- 4.1.4. Салбар танхимын дарга байна.
- 4.2. Салбар танхимын бүх гишүүдийн хурал
  - 4.2.1. Салбар танхимын эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал байх бөгөөд жилд нэг удаа хуралдана.
  - 4.2.2. Салбар танхимын гишүүдийн тавны нэгээс доошгүй хувийн санал, эсвэл тэргүүлэгчдийн хурлын шийдвэрийн дагуу ээлжит бус бүх гишүүдийн хурлыг хийж болно.
  - 4.2.3. Бүх гишүүдийн хурал хуралдах хугацаа, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг Салбар танхимын тэргүүлэгчид батлаж, хурал эхлэхээс 14 хоногийн өмнө Салбар танхимын гишүүдэд албан ёсоор мэдэгдэнэ. Мөн бүх гишүүдийн хурлын талаарх албан мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан гишүүдэд хүргэнэ.
  - 4.2.4. Гишүүд нь бүх гишүүдийн хуралд өөрөө буюу эрх бүхий албан тушаалтнаар дамжуулж оролцоно. Хэрэв ээлжит хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухайгаа урьдчилан мэдэгдэх бөгөөд байгууллагынхаа итгэмжлэгдсэн төлөөлөгчийг оролцуулж болно. /итгэмжлэгдсэн төлөөлөгчийг наторатоор баталгаажуулна./
  - 4.2.5. Салбар танхимын бүх гишүүдийн хурал нь нийт гишүүдийн 51-ээс доошгүй хувь ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцогдох ба асуудлыг тухай үеийн байдлаас шалтгаалан ил буюу далд санал хураах байдлаар авна.
  - 4.2.6. Салбар танхимын үйл ажиллагааг зогсоож, татан буулгах асуудлыг бүх гишүүдийн хурлын нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар уг дүрмийн 7-р зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 4.3. Салбар танхимын бүх гишүүдийн хурал дараах эрх, үүрэгтэй
  - 4.3.1. Салбар танхимын дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах
  - 4.3.2. Салбар танхимын үйл ажиллагааны тайлан илтгэлийг хэлэлцэж шийдвэрлэнэ.
  - 4.3.3. Салбар танхимын дарга, тэргүүлэгчдийг сонгох, батлах
  - 4.3.4. Салбар танхимын үйл ажиллагааг зогсоох, татан буулгах асуудлыг Үндэсний танхимтай хэлэлцэн шийдвэрлэх
  - 4.3.5. Салбар танхимын үйл ажиллагаатай холбогдсон бусад асуудлыг хэлэлцэх
- 4.4. Салбар танхимын тэргүүлэгчид
  - 4.4.1. Салбар танхимын тэргүүлэгчид нь бүх гишүүдийн хурлын хооронд танхимын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй бөгөөд 3 сард нэг удаа хуралдана.
  - 4.4.2. Салбар танхимын тэргүүлэгчид нь 2 жилийн хугацаатай сонгогдоно.

- 4.4.3. Салбар танхимын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд салбар танхимын дарга орно.
- 4.4.4. Тэргүүлэгчдийн хурлыг Салбар танхимын дарга удирдана.
- 4.4.5. Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр гармагц хүчин төгөлдөр болно.
- 4.5. Салбар танхимын тэргүүлэгчдийн эрх, үүрэг
  - 4.5.1. Салбар танхимын жилийн ажлын төлөвлөгөөг, хэлэлцэн батлаж, гүйцэтгэлд нь хяналт тавих
  - 4.5.2. Салбар танхимын гишүүний хураамжийн хэмжээг тогтоох
- 4.6. Салбар танхимын Тэргүүлэгчдийн тавиас доошгүй хувь нь ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцох ба олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 4.7. Салбар танхимын Ерөнхийлөгч
  - 4.7.1. Салбар танхимын ерөнхийлөгч нь орон тооны бус хүн байна.
  - 4.7.2. Салбар танхимын дарга болон тэргүүлэгчдийн үйл ажиллагаанд хяналт тавина.
  - 4.7.3. Салбар танхимын дарга болон тэргүүлэгчдийн үйл ажиллагаанд оролцсон идэвхи санаачлагыг дүгнэн тэргүүлэгчдийг шагнан урамшуулах асуудлыг салбар танхимын ерөнхийлөгч шийдвэрлэнэ.
  - 4.7.4. Салбар танхимын даргын ажил үүргийн хуваарийг батална.
- 4.8. Салбар танхимын дарга.
  - 4.8.1. Салбар танхимын үйл ажиллагааг салбар танхимын дарга удирдан зохион байгуулах бөгөөд түүнийг тухайн салбар танхимын бүх гишүүдийн хурлаас санал болгосны дагуу үндэсний танхимын дарга 4 жилийн хугацаатай томилно.
  - 4.8.2. Салбар танхимын тэргүүлэгчдийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтийг хангана.
  - 4.8.3. Салбар танхимын орон тоо, цалингийн схем, сангуудын хэмжээ, шагнал урамшуулал олгох журмыг тэргүүлэгчидтэй зөвшилцөн батална.
  - 4.8.4. Салбар танхимын үйл ажиллагаа менежментийг удирдан чиглүүлж, өдөр тутмыг удирдлагаар хангаж, удирдах байгууллагуудын өмнө хариуцлага хүлээнэ.
  - 4.8.5. Салбар танхимын нэрийн өмнөөс гадаад дотоодын байгууллага аж ахуйн нэгжүүдтэй харилцах, гэрээ, хэлэлцэл хийх, шүүхэд нэхэмжлэгч хариуцлагчаар оролцоно.
  - 4.8.6. Эрх хэмжээнийхээ асуудлаар Салбар танхимын ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр тушаал гаргана.
  - 4.8.7. Танхимын үйл ажиллагааны талаар бүх гишүүдийн хурал болон үндсэний танхимд тайлагнах
- 4.9. Салбар танхимын Хяналтын зөвлөл

4.9.1. Салбар танхимын хяналтын зөвлөл нь 3 хүний бүрэлдэхүүнтэй 2 жилийн хугацаагаар сонгогдох бөгөөд Танхимын тэргүүлэгч гишүүд болон захиргааны ажилтнууд Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд орохгүй

4.9.2. Хяналтын зөвлөлийн даргыг гишүүдээс нууцаар санал хурааж олонхийн саналаар сонгоно.

4.9.3. Хяналтын зөвлөл эрхлэх үйл ажиллагаандаа удирдлага болгох дотоод журамтай байна. Дотоод журмыг хяналтын зөвлөлийн хурлаар батална.

4.9.4. Хяналтын зөвлөл танхимын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, касс, эд хөрөнгийн тооцоо бүртгэл, тогтоол, тушаалын биелэлтийг 2 жилд нэгээс доошгүй удаа шалгаж бүх гишүүдийн хуралд тайлагнана.

#### Тавдугаар бүлэг. Бусад

5.1. Салбар танхимын эд хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө тэдгээртэй адилтгах бусад активаас бүрдэнэ.

5.2. Салбар танхимын эд хөрөнгө нь гишүүдийн татвар, хандив, зээл, тусламж, өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого тэдгээртэй адилтгах хөрөнгөнөөс бүрдэнэ.

5.3. Салбар танхим нь ашиг орлого олох зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулахгүй боловч танхимын хууль болон төрийн бус байгууллагын тухай хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлж өөрийгөө санхүүжүүлнэ.

#### Зургаадугаар зүйл. Салбар танхимаас төр, засгийн болон бусад байгууллагатай харилцах

6.1. Монгол улсын хуульд зааснаас бусад тохиолдолд төр, засгийн байгууллагаас танхимын үйл ажиллагаанд, танхимаас төр, засгийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй.

6.2. Салбар танхим нь төр, засгийн баримталж байгаа эдийн засгийн бодлогыг дэмжин дэлгэрүүлэх, гадаад, дотоодод тайлбарлан таниулах, хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэхийн зэрэгцээ тодорхой асуудлаар салбар танхимын гишүүд, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид, худалдааныхны нийтлэг эрх ашиг, сонирхолыг илэрхийлэн хамгаалах үүднээс төр, засгийн байгууллагатай зөвшилцөх, хэлэлцээ хийх, шаардлага тавих зэрэгт Үндэсний танхимаар дамжуулан хамтран ажиллана.

6.3. Салбар танхим бусад төрийн бус байгууллага, худалдаа, үйлдвэрлэлийн нийгэмлэг, холбоод, танхимтай харилцахдаа хууль дээдлэх, харилцан хүндэтгэх, дэмжин туслах, шударга байх, хамтран ажиллах зарчим баримтлана.

#### Долдугаар зүйл. Салбар танхимын үйл ажиллагааг зогсоох

7.1. Салбар танхимын үйл ажиллагааг зогсоох асуудалд үндэсний танхим давуу эрхтэй байна. Үндэсний танхим нь салбар танхимын үйл ажиллагааг зогсоох асуудлыг салбар танхимын гишүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ